



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/156

Алтай хот

Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн
ангийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалт, 33 дугаар зүйл, Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалаар баталсан Мэргэжлийн ангийн дүрмийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн гамшгаас хамгаалах алба, тусгай зориулалтын мэргэжлийн ангийг нэгдүгээр хавсралтаар, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг томилж, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулан, хяналт тавьж, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Лувсанжамц)-т даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/79 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 20... оны
 03... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
 захирамжийн нэгдүгээр хавсралт

ОРОН НУТГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА,
 АЛБАНЫ ДАРГА, ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН
 АНГИЙН ЖАГСААЛТ, ЧИГ ҮҮРЭГ

№	Орон нутгийн гамшгаас хамгаалах албаны нэр	Албаны дарга	Түшиглэн ажиллах байгууллага	Харьяалагдах мэргэжлийн ангийн зориулалт	Харьяалагдах мэргэжлийн ангийн ангилал	Чиг үүрэг
1	1. Удирдлага зохион байгуулалт, мэдээлэл, сурталчилгааны алба	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Санхүү, нөөц, зохион байгуулалт мэдээлэл, сурталчилгаа	Санхүү, нөөц, зохион байгуулалт, мэдээлэл, сурталчилгааны бүлэг	Алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулах Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр нөөц хөрөнгө бүрдүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шаардлагатай мөнгөн хөрөнгө, зэвдлэг тооцох, шийдвэрлүүлэх Гамшиг, ослын үед шаардагдах төрөл бүрийн хангалтын нөөцийг холбогдох норм, стандартын дагуу бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, сэлгэх ажлыг зохион байгуулах, Хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн ангитай хамтран нөөцийн бараа бүтээгдэхүүнийг хуваарилах ажлыг зохион байгуулах Гамшиг, ослын нөхцөл байдлын талаарх бодит мэдээллээр хангах, гамшгийн үед иргэдэд ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах


2			Статистикийн хэлтэс	Статистик мэдээлэл	Статистик мэдээллийн бүлэг	Мал амьтан, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, хүч хэрэгслийн тооцоо судалгаа гаргах
3		Говь-Алтай аймгийн Улаан загалмайн хороо	Хүмүүнлэгийн тусламж	Хүмүүнлэгийн тусламжийн бүлэг	Хүмүүнлэгийн тусламжийн бүлэг	Нэрвэгдэгсдэд холбогдох дүрэм, журмын дагуу дотоодын нөөцөөс хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн Олон Улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах
4		БОАЖГ	Байгалийн болон химийн аюул	Цацраг, химийн аюулаас хамгаалах бүлэг	Цацраг, химийн аюулаас хамгаалах бүлэг	Гамшиг, ослын голомтод цацраг, химийн тандэлт явуулах, үнэлэлт өгөх, цацрагийн түвшингийн хэмжилт хийх, эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, саармагжуулах ба идэвхгүйжүүлэх, ариутгал цэвэрлэгээ хийх
5	2. Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа	Уст цэг, түүнийг хамгаалах бүлэг	Уст цэг, түүнийг хамгаалах бүлэг	Усны эх үндэргэ, усны сан бүхий газар, уст цэгийн бохирдолтод шинжилгээ хийх, усыг бохирдох, хор, халдвараас хамгаалах, ариутгал хийх, шинээр худаг ус гаргах, ус тээвэрлэх, түгээх, үер усны аюулаас хамгаалах асуудал хариуцах
6		УЦУОШТ	Байгалийн болон химийн аюулыг үнэлэх бүлэг	Байгалийн болон химийн аюулыг үнэлэх бүлэг	Байгалийн болон химийн аюулыг үнэлэх бүлэг	Байгалийн болон химийн аюулыг үнэлж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
7		Газар хөдлөлтийг бүртгэх Алтай станц	Газар хөдлөлтийн тандалтын бүлэг	Газар хөдлөлтийн тандалтын бүлэг	Газар хөдлөлтийн аюулыг тандэх, мэдээлэх	Газар хөдлөлтийн аюулыг тандэх, мэдээлэх
8	3. Барилга, хот байгуулалтын алба	Газрын харилцаа барилга хот	Газрын харилцаа барилга хот	Нүүлгэн шилжүүлэлтийн түр байр	Нүүлгэн шилжүүлэлтийн түр байрны бүлэг	Гамшиг, ослын голомтоос нүүлгэн шилжүүлэхэд түр байр дэлгэх арга хэмжээг зохион байгуулах




9		байгуулалтын газрын дарга	байгуулалтын газар	Хоргодох байр	Хоргодох байрны бүлэг	Гамшиг, ослын /хүхтэй шуурга, цацраг, хими биологийн аюул/ үед хүн амыг түр байрлуулах хөргөдох байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах
10	4.Зам, тээврийн алба	Авто тээврийн төвийн дарга	Авто тээврийн төв	Тээвэр	Тээврийн бүлэг	Нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшиг, ослын голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээ үзүүлэх
11			"АЗЗА" ТӨХК	Зам, гүүрийн засвар, үйлчилгээ	Зам, гүүрийн засварын бүлэг	Гамшиг, ослын улмаас нурсан, эвдэрсэн зам, гүүрт засвар хийх, гарц гаргах, түр гүүр тавих, хойшуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
12			Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар.		Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах бүлэг	Гамшиг, ослын үед өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн асуудлыг зохион байгуулах, голомтын бүсээс эхний ээлжинд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
13	5.Хүн ам, нийгмийн хамгааллын алба	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	Нийгмийн хамгаалал	Хүүхэд хамгаалал, боловсролын бүлэг	Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохион байгуулах
14			Улсын бүртгэлийн хэлтэс	Иргэний бүртгэл мэдээлэл	Иргэний бүртгэл, мэдээллийн бүлэг	Гамшиг, ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргаж өгөх



15				Ургамал, газар тариалан хамгаалах бүлэг	Химийн, хоргүй, байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга технологийг бэлчээрийн болон тариалангийн талбайд хөнөөл учруулдаг хортон шавьж, мэрэгчдийн тархалттай тэмцэх, үрийн агуулах, техник, тоног-техөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдал, стандартын шаардлагыг хангуулах
16		Хүнс, хөдөө аж ахуйн газар		Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүлэг	Мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, цацраг идэвхт болон химийн хорт бодисоор хордсон талбай, халдварт өвчний голомт, голомтод байсан хүн, техник хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ хийх
17	6. Хүнс, хөдөө аж ахуйн алба	Хөдөө аж ахуйн газрын дарга	Хүнс, хөдөө аж ахуй	Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн бүлэг	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, халдварын голомт дахь мал, амьтанд үзлэг тандалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хорио цээрийн дэглэм тогтоох, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу авч хэрэгжүүлэх
18		"Ундрага-Алтай" ОНӨААТҮГ		Цэвэр, бохир усны засварын бүлэг	Цэвэр, бохир усны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босгох ажил гүйцэтгэх
19		"Буудайн хөх уулс" ХХК		Хүнсний хангалтын бүлэг	Нэрвэгдэгсэд болон гамшиг, ослын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг ус, хоол, хүнсээр хангах
20	7. Тулш, эрчим хүчний алба	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн	Цахилгаан хангамж	Цахилгаан, шугам сүлжээний засварын бүлэг	Гамшиг, ослын үед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц, шугаманд гарсан эвдрэл гэмтлийг засварлах, хойшуулушгүй сэргээн босгох ажлыг



21	ийн захирал	"Солонго дулааны станц" ААТҮГ, "Мандап голомжт" ХХК	Дулаан хангамж	Дулааны шугам сүлжээний засварын бүлэг	Дулааны эрчим хүчний системийн аюулгүй ажиллагааг хангах, шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг илрүүлэх, засвар үйлчилгээ хийх, хойшуулушгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
22		ШТС-ууд	Шатахуун, хийн түлш хангалт	Шатахуун, хийн түлш хангалтын бүлэг	Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэж байгаа автомашин, бусад техник хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх, хангах, нөөц бүрдүүлэх
23				Яаралтай тусламжийн бүлэг	Гамшгийн голомтод нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилж, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлэгт тээвэрлэн хүргэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах
24	8. Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Хээрийн эмнэлэг	Хээрийн нөхцөлд нэрвэгдэгсдэд эмнэлгийн шаардлагатай бүхий л төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэл зүйн лабораторийн шинжилгээ хийх, өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах
25				Цус сэлбэх хөдөлгөөнт бүлэг	Нэрвэгдэгсдийг цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээгээр хангах, нөөц бүрдүүлэх, тээвэрлэх, хүргэх ажлыг зохион байгуулах
26				Эм, эмнэлгийн хэрэгслээр хангах бүлэг	Гамшиг, ослын үед хээрийн эмнэлэг болон яаралтай тусламжийн хэсгийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, хээрийн нөхцөлд хөдөлгөөнт эмийн сан ажиллуулах
27				Зоонозын өвчинтэй тэмцэх бүлэг	Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, голомтыг цомхотгож хор уршгийг арилгах зорилгоор эмчлэн тусгаарлах, хавьтлыг




28					Сэтгэл зүйн Дэмжлэг үзүүлэх бүлэг	Тогтгож хяналтад авах, халдваргүйтгэл хийх зэрэг хариу арга хэмжээ авах Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн анхны тусламж, дэмжлэг үзүүлэх гэмшгийн дараах стрессийг бууруулах, сэтгэл гутралыг багасгах, хүмүүсийн даван туулах итгэл найдварыг сэргээх, бусадтай харилцах, холбоо тогтооход нь туслах Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн эрэн хайх, аврах ажиллагааны багийн гишүүдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх
29	9.Мэдээлэл, харилцаа холбооны алба	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ийн захирал	Мэдээлэл холбооны сүлжээ Шуудан холбоо, Монголын цахилгаан холбоо	Зарлан мэдээлэл, харилцаа холбоо	Зарлан мэдээлэл, харилцаа холбооны бүлэг	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, холбогдох албан тушаалтны шийдвэрээр харьяа нутаг дэвсгэртээ зарлан мэдээлэл дамжуулах Гамшиг, ослын үед Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, гамшгаас хамгаалах алба, штаб, шуурхай бүлгийн удирдлагын байр, мэргэжлийн ангийг найдвартай холбоогоор хангах, холбооны шугамд гарсан гэмтлийг засварлах, сэргээн босгох
30	10.Хэв журам сахиулах алба	Цагдаагийн газрын дарга	Цагдаагийн газар	Хэв журам сахиулах ажиллагаа	Хэв журам сахиулах бүлэг	Гамшиг, ослын үед нийгмийн хэв журам сахиулах, эрэн хайх, аврах ажиллагаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорио цээрийн дэглэмийн үеийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох



31			Дотоодын цэргийн тусгай салбар		Улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах зэрэг бусад хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд ажиллах
32		Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай аймаг хэлтэс	Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай аймаг дахь хэлтэс	Терроризмтэй тэмцэх	Тусгай бүлэг
33	11.Терроризмтэй тэмцэх алба	Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай аймаг хэлтсийн дарга	Алтай нисэх буудал	Нисэх буудлын аюулгүй байдал	Нисэх буудлын аюулгүй байдлын бүлэг
34	12.Гал түймэртэй тэмцэх алба	Онцгой байдлын газрын дарга	Онцгой байдлын газар	Гал унтраах ажиллагаа	Гал түймэр унтраах бүлэг

Аймгийн Засаг даргын 2015 оны
 дугаар сарын 1-ны өдрийн дугаар
 захирагчийн хөдөлгөөнд хавсралт



ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН
 АНГИЙН ЖАГСАЛТ

№	Сумын нэр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20
	Алтай	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Баян-Уул	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Бичэр	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Бутаг	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Дарна	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Дэлгэр	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Жаргалан	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Тайшир	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Тонхил	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Төрөг	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Халиун	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Хөхморьт	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Цогт	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Цэцэг	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Чандмань	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Шарга	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Эрдэнэ	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Есөнбулаг	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Гуулин	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Баянтоорой	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+